



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны  
9 дүгээр сарын 28-ны өдрийн Р-2023-71 дугаар тогтоолын Хавсралт



**ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ  
СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ЖУРАМ**

Хувилбар	2.0
Баталсан огноо	2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр
Нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн баталсан огноо	2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр
Баталсан	Төлөөлөн удирдах зөвлөл
Боловсруулсан	Төлөөлөн удирдах зөвлөлийн Ажлын алба
Холбогдох эрх зүйн баримт бичгүүд	<ul style="list-style-type: none"><li>▪ Компанийн тухай хууль</li><li>▪ Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодекс</li></ul>
Дагаж мөрдөх Нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, хүчингүй болгох	Банкны хэмжээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батална.

## АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ХЭМЖЭЭ, БҮРЭЛДЭХҮҮН
3. ТУЗ-ИЙН ГИШҮҮНД ТАВИГДАХ ШАЛГУУР
4. НЭР ДЭВШИГЧИЙГ ТОДОРХОЙЛОХ
5. ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ ТОМИЛОХ, ДАХИН ТОМИЛОХ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. ХасБанкны Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх өрөнхий журам (“Журам”)-ын зорилго нь ХасБанкны алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилтод нийцүүлэн ХасБанкны стратегийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх, нийт хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, дэмжих зорилгоор Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийн үндсэн үүргийг гүйцэтгэх зохих ур чадвар, давуу тал бүхий гишүүдээр ТУЗ-ийг бүрдүүлэхэд оршино.
- 1.2. Энэхүү журмаар ХасБанкны ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг бий болгох, шинэчлэх, ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр ажиллах боломжит хүмүүсийг сонгон шалгаруулж, үнэлэх, ТУЗ-д нэр дэвших, улируулан томилогдох зэрэг үйл ажиллагааны журам, аргачлалыг тогтооно.
- 1.3. Энэхүү журмыг ХасБанкны ТУЗ-ийн засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (“Хороо”) хэрэгжүүлнэ.
- 1.4. Энэхүү журмыг ХасБанкны Дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийн хамт мөрдөх бөгөөд энэхүү журмаар зохицуулаагүй харилцаанд ХасБанкны Дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтална.

### Хоёр. ТУЗ-ийн бүтэц, хэмжээ, бүрэлдэхүүн

- 2.1. ХасБанкны ТУЗ нь хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудаас гадна ХасБанкны эрх ашгийг бүхэлд нь хамгаалж чадахуйц, аливаа зүйлийг өргөн хүрээнд авч үздэг, ур чадвартай, үр дүнтэй шийдвэр гаргах боломжийг олгосон бүтэц, бүрэлдэхүүнтэй байна.
- 2.2. Хороо нь компанийн өнөөгийн болон цаашдын хэрэгцээ шаардлагыг тогтоож, ТУЗ-д байх шаардлагатай бүтцийг бий болгохын тулд ТУЗ-ийн бүтэц, хэмжээ, бүрэлдэхүүнд тогтмол хяналт тавина:
  - Компанийн өнөөгийн болон шинээр үүсч буй асуудлуудын талаар зохих ойлголттой, шийдвэрлэх чадвартай байх;
  - ТУЗ-ийн ердийн гишүүдийн бүрэлдэхүүнд гүйцэтгэх удирдлагаас зохистой хэмжээнд оруулна;
  - Хараат бусаар дүгнэлт хийх чадвартай байх;
  - ХасБанкны үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлдэг байх;
  - Удирдлагын гүйцэтгэлд хяналт тавих чадвартай байх, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлтэй холбоотойгоор шаардлага тавих.
- 2.3. Хороо нь ТУЗ-ийн үр дүнтэй ажиллах боломжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай байгаа ур чадварыг тодорхойлох зорилгоор одоо ажиллаж байгаа ТУЗ-ийн ур чадвар, туршлага, мэргэшсэн байдал зэргийг үнэлнэ.
- 2.4. Хороо нь ТУЗ-ийн гишүүн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгох шалгуурыг боловсруулах ба аливаа өөрчлөлтийн талаар ТУЗ-д санал оруулна.

- 2.5 Хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүдийн залгамжийн бодлого болон залгамжийн төлөвлөгөөг боловсруулах үүрэгтэй. Энэхүү бодлогын баримт бичгээр ТУЗ-ийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор ТУЗ-ийн гишүүний ажил үүргийг залгамжлах боломжтой этгээдийг олж тогтоох, тэдгээрийг бэлтгэхтэй холбоотой үйл ажиллагааны журмыг тодорхойлно. Хороо нь энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ТУЗ-ийн хараат бус гишүүдийн орон тоонд ирээдүйд ажиллах хүний нөөцийг бурдүүлж, тогтмол шинэчилж болно.
- 2.6 ТУЗ-ийн ердийн гишүүн болон хараат бус гишүүний ажлын байранд сул орон тоо гарсан тохиолдолд Хороо нь тухайн сул орон тоонд ажиллах боломжтой нэг буюу хэд хэдэн нэр дэвшигчийг тодорхойлох ба нэр дэвшигч бүрийг судалж, ТУЗ-д ажиллахад тохирох эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, ТУЗ-д санал болгох үүрэгтэй.
- 2.7 Хороо нь жил бүрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн гишүүн болон хараат бус гишүүнээр сонгогдох болон улиран сонгогдох боломжтой нэр дэвшигчдийг санал болгох үүрэгтэй.

#### Гурав. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шалгуур

- 3.1 ТУЗ-ийн гишүүнээр ажиллах нэр дэвшигчийн ур чадварыг тодорхойлж, үнэлэхдээ дараах шалгуурыг харгалзан үзнэ:
1. Монгол Улсад оршин суудаг байх нь давуу тал болно;
  2. ТУЗ-ийн бусад гишүүнд байх холбогдох ур чадвартай байх;
  3. ХасБанкны бизнесийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий, тухайн салбарын асуудлыг ойлгох тодорхой туршлага, харилцаа холбоо, бизнесийн туршлага, ур чадвартай байх;
  4. Олон улсын болон Монгол Улсын бизнесийн орчинд танигдсан, нэр хүндтэй, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, ихээхэн туршлагатай, мэргэжлийн үйл ажиллагааны хувьд амжилт гаргасан байх;
  5. ТУЗ болон хорооны асуудлаар өөрийн ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хангалттай цаг хугацаа зарцуулах боломжтой байх, ТУЗ-д ажиллах чадвар, хүсэл эрмэлзэлтэй байх;
  6. ХасБанкны үнэт зүйлд нийцүүлэн өргөн хүрээний асуудлаар бизнесийн үнэн зөв дүгнэлт хийж, хувийн болон мэргэжлийн ёс зүйтэй, шударга байх.
- 3.2 Банкны ТУЗ-ийн гишүүнд болон хараат бус гишүүнд нэр дэвшигч нь Монгол Улсын банкны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компанийтай холбоотой харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан тодорхой ур чадвар, шалгуурыг хангасан байна. Түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигч нь Компанийн тухай хуульд заасан хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүнд тавигдах шалгуурыг хангасан байна.
- 3.3 ТУЗ-ийн гишүүн болон ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь дор дурдсан харилцаанд орсон бол сонирхлын зөрчилтэйд тооцогдоно:
- (а) Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Банк (ХасБанкнаас бусад)-ны эрх бүхий албан тушаалтан, ажилтан, эсхүл гаргасан хувьцааны 1 ба түүнээс дээш

хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч (эсхүл сүүлийн 12 сарын дотор байсан) бол;

- (b) ХасБанкны нийт хөрөнгийн 2 хувиас дээш дүнтэй тэнцэх хэмжээний нийт хөрөнгө бүхий Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Санхүүгийн нэгдэл (ТэнГэр Санхүүгийн Нэгдлээс бусад), ББСБ эсвэл Зээлийн агрегаторын эрх бүхий албан тушаалтан, ажилтан эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшигч (гаргасан хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмших хувьцаа эзэмшигч) (эсхүл сүүлийн 12 сарын дотор байсан) бол.

#### Дөрөв. Нэр дэвшигчийг тодорхойлох

- 4.1 Хороо нь ТУЗ-ийн гишүүнд болон хараат бус гишүүнд нэр дэвшигчийг тодорхойлох бүх төрлийн эх сурвалжийг ашиглаж болох ба хайж олохдоо нээлттэй зарлах болон бусад арга замаас гадна тохиromжтой гэж үзсэнийгээ ашиглаж болно.  
Хороо нь ТУЗ-ийн гишүүнд тохирох нэр дэвшигчийг хайхад болон нэр дэвшигчдийн суурь хүмүүжил, боловсрол, туршлага зэрэг холбогдох мэдээлэл цуглуулахад тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хөндлөнгийн компанийг оролцуулан тэдгээрээс дэмжлэг авч болно.
- 4.2 Хороо нь ТУЗ-ийн ердийн гишүүн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчийн суурь хүмүүжил, боловсрол, зан байдал, ур чадварыг нарийвчлан судлах, тухайн нэр дэвшигч ТУЗ болон Хорооны нэг болон хэд хэдэн гишүүдтэй, эсхүл Хорооны бүх гишүүдтэй биечлэн ярилцлага хийх зэрэг нэр дэвшигчийг судлах, үнэлэхтэй холбоотой шаардлагатай гэж үзсэн бүхий л үйл ажиллагаанд оролцох эрхтэй.
- 4.3 Хороо нь нэр дэвшигчтэй холбоотой санал боловсруулахдаа судалгаа, үнэлгээний үр дүн, дүгнэлтээс гадна ТУЗ-ийн одоогийн бүрэлдэхүүн, тэдгээрийн онцлог шинж, үр чадвар, ТУЗ-д нэмэлтээр шаардлагатай байгаа онцлог шинж, нөөц бололцоо, ур чадвар болон нэр дэвшигч нь эдгээрийг хангаж байгаа эсэхийг харгалзан үзнэ.
- 4.4 Нэр дэвшигч ТУЗ-ийн гишүүнээр ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлж, хэрэв сонгогдвол ТУЗ-ийн ажил үүрэгт тавигдах шаардлагыг биелүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд Хороо нь ямар ч нэр дэвшигчийг санал болгохгүй.

#### Тав. ТУЗ-ийн гишүүнийг томилох, улируулан томилох

- 5.1 Хороо нь Монголбанкнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр ТУЗ-ийн ердийн гишүүн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчийн талаар ТУЗ-тэй зөвшилцэж, ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хуралд санал боловсруулж хүргүүлнэ. ТУЗ-ийн гишүүний ажлын байранд гэнэтийн сул орон тоо гарсны улмаас түр томилгоо хийх шаардлагатай болсон тохиолдолд Хороо нь уг түр томилгооны талаарх саналаа ТУЗ-д шууд хүргүүлж, хэлэлцүүлэн батлуулна. Энэ саналын хувьд Хорооны үнэмлэхүй олонхийн санал шаардлагатай байна.
- 5.2 ТУЗ-ийн гишүүн болон хараат бус гишүүнд сонгогдохоор танилцуулагдаж байгаа нэр дэвшигчдийн нэrs болон тэдгээрийн ТУЗ-д ажилласан нийт хугацаа, өмнөх хугацаанд хийсэн ажлууд, гаргасан ололт амжилт зэргийг тодорхойлсон дэлгэрэнгүй тайлан, ТУЗ-өөс гаргасан гүйцэтгэлийн үнэлгээ зэргийг хамтад нь танилцуулна. ТУЗ-ийн хараат бус гишүүний орон тоонд нэр дэвшигчийн хараат бус

байдлыг хэрхэн тодорхойлсон эсэх, мөн бусад компанийн эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг эсэх талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд дэлгэрэнгүй танилцуулна.

(Энэхүү шаардлагыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлнэ.)

- 5.3 ТУЗ-ийн гишүүн болон хараат бус гишүүнийг улируулан томилохдоо тогтмол хугацаанд дахин сонгон шалгаруулалтад оруулах бөгөөд гүйцэтгэл нь үргэлжлүүлэн ажиллахад хангалттай байна.

-о0о-